“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4 сарын 30 өдөр Дугаар: 26/001 Улаанбаатар хот

ТАЙЛАН, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2026 оны 4 сарын 30–ны өдрийн тооллогын комиссын 26/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бизнес төлөвлөгөөг хавсралтаар батлан зөвшөөрсүгэй.
3. Нэмж хувьцаа гаргах, өөрчлөн байгуулах нөхцөл бүрдсэн үед үнэт цаасны танилцуулга болон холбогдох дүгнэлтүүдийг батлахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА **Р.ОТГОНБАТ**

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4 сарын 30 өдөр Дугаар: 26/002 Улаанбаатар хот

НЭМЖ ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62.1.3, 18, 20, 32.5 заалтууд, 2026 оны 4-р сарын 30–ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 26/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтиер Лэнд Групп” ХК нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх, хувьцааныхаа төвлөрлийг сааруулах зорилгоор 10 тэрбум төгрөг хүртлэх үнийн дүн бүхий энгийн хувьцаа нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа нэмж гаргаж байгаатай холбогдуулан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, хувьцааг хуваах эсвэл нэрлэсэн үнийг буулгах, компанийг нэгтгэх зэрэг өөрчлөн байгуулах ажлуудыг хийж гүйцэтгэсүгэй.
3. Дээрх арга хэмжээг авч хувьцаа нэмж гаргах тоо ширхэг, үнийг тогтоон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан арга хэмжээ авч ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА **Р.ОТГОНБАТ**

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4 сарын 30 өдөр Дугаар: 26/004 Улаанбаатар хот

ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ЭРХ ЭДЛҮҮЛЭХ ЭСЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 38-р зүйл, 2026 оны 4-р сарын 30–ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 26/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн нэмж гаргаж буй хувьцааг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг одоогийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА Р.ОТГОНБАТ

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4 сарын 30 өдөр | Дугаар: 26/006 | Улаанбаатар хот

“МОРЬТ ИМПЕКС” ХХК-ТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭГ ДҮГНЭХ, ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭГ АВАХ

Компанийн тухайн хуулийн 62-р зүйлийн 62.1.3 дах заалт, 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 26/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани болон анхны үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул сонгино усны цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээг сунгасан гэрээний хугацаа дуусгавар болсон, уг гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс уг гэрээг дахин нягтлан судалж, шаардлагатай арга хэмжээг аван нэмэлт өөрчлөлт оруулан гэрээг шинэчлэн байгуулсугай.
2. Шинэчилсэн гэрээг хавсралтын дагуу баталсугай.
3. Анхны үүсгэн байгуулагч нартай гэрээ байгуулан гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах тал дээр идэвхи чармайлт гарган ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА **Р.ОТГОНБАТ**

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4 сарын 30 өдөр Дугаар: 26/005 Улаанбаатар хот

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлүүд 2026 оны 4-р сарын 30–ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 26/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийг өөрчлөн байгуулах, нэмж гаргах нэмэлт хувьцааг төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрсний дараа нэмэлт хувьцаа гаргах шийдвэртэй санал нийлэхгүй байгаа эсхүл хуралд оролцож санал өгөөгүй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэдгийг тухайн үед нь хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
2. Хувьцаагаа эргүүлэн Компанид зарах хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эргүүлэн худалдан авах журмыг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс шийдвэр гарсны дараа боловсруулан хувьцаа эзэмшигчдэд танилцуулсугай.
3. Компани хувьцааг буцаан худалдан авсны дараа төлбөрийн чадвартай үлдэх ёстой гэдгийг санан буцаан худалдан авах үнийг тогтоон энэхүү ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл-д үүрэг болгосугай.

ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК FRONTIER LAND УЛААНБААТАР ХОТ 1115209412 5106583

ХУРЛЫН ДАРГА **Р.ОТГОНБАТ**